

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Рагчаа	Дугаар	L188
Оршин суугаа аймаг	Говь-Алтай аймаг	Оршин суугаа сум	Жаргалан
Төрсөн газар	Жаргалан	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Арын хүрээ	Сүм хийдийн дугаар	ГАЗГ 114
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Арын хүрээ

2007 оны **8-р сарын** 30-ны өдөр. Судалгааны баг Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Тээл багийн өндөр настан Рагчаа гуайтай уулзаад байна.

Асуулт:-Рагчаа гуай та бидэнд энэ сумын нутагт байсан Арын хүрээний тухай ярьж өгнө үү.

Хариулт:-Арын хүрээ анх байгуулагдсан оныг нь мэдэхгүй юм. Энэ Өвгөн Хүрээ гэж байгаад дээшээ нүүж очоод Арын Хүрээ байгуулагдаад тэр үеийн **Дангиа** мужаан гэдэг хүн .

Асуулт:-Монгол хүн байсан уу?

Хариулт:-Мужаан хийгээд тэр Цогчэн жинхэнэ том дуганыг нь барьж л дээ. Тэр үед чинь том дугануудыг бариад нас өгдөг байсан юм байна. Гол баганыг нь цохиод.

Асуулт:-Төдөн жилийн настай гээд үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Тийм. 20 жилийн нас өгсөн гэж байгаа юм. Андуураад ч тэгсэн юмуу, зайлшгүй тэр цаг түүх нь болоод ч тэгсэн юм. Тийм нас өгсөн юм гэнэ лээ. Ер нь 20 жил дээрээ тарсан гэсэн байхаа. Манай хөгшчүүл тэгж ярьдаг байсан. Тэр ямар ч байсан 20 жилийн хугацаанд **Баажуу** гэгээн гэдэг тэр толгойлж, удирдаж байсан юм гэнэ лээ.Тэгэхээр өөрөө бол ар тал нь тусгай ордтой, том гэр, тусгай няравтай жижиг **нэг тийм** тустай хийдтэй байсан юм. Тэрний сойвон ч байж байгаа. Одоо.

Асуулт:-Энэ хийдийн гол шүтээн нь ямар бурхан байсан юм бол, Арын хүрээний?

Хариулт:-Төрөл бүрийн бурхан байсан байх, ялангуяа их суумал, гуулин **бурхад** их байсан л даа. Тэрнийг нь аль дуган билээ нэг дуган дотор нь хийгээд шатаачихсан **байгаа юм**. Би бага байхдаа хонь хариулж яваад ухаж бариад гуулин бурхан гаргаж ирдэг л байлаа. Сүүлд нь манай сумын нэгдлийн дарга Чимид гэж байхдаа трактораар ухаж л байлаа. Ухаад ч нэг их гарсан ч юм байхгүй.

Асуулт:-Толгойлж байсан лам нь **Баажав** гэдэг хүн байсан уу?

Хариулт:-Тийм.

Асуулт:-Унзад **гэсгүй** гээд лам нарыг нь мэдэх үү?

Хариулт:-Мэдэхгүй. Жиндээ **Чанзав** гээд хүн байсан юм билээ. Тэр үед чинь шашны нэг **төлөөлөгчүүд** хоорондоо Бигэрийн хүрээ гээд.

Асуулт:- Бигэр номун хааны хүрээ?

Хариулт:-Бигэр номун хааны хүрээнд Жиндээ **Чанзав** гэдэг хүн тэнд очиж сууж байсан. Шашны төлөөлөгч л юм даа. Тэр манай эндхийн хүн гэж байгаа юм, тэнд очиж байж байсан. Ер нь нийтдээ ном заалгасан ч байдаг юмуу, 50, 60-аад ламтай байсан юм шиг байна лээ.

Асуулт:- Ламын хүрээ юу?

Хариулт:- Тийм. Гэлэн, санваар гэсэн улсууд бас овоо байсан л даа. Тэнд байж байсан улсуудаас яг тэр хүрээ тараад сүүлд нь хэсэг улсууд баригдаад явсан л даа.

Асуулт:- Хэдэн оны үед баригдсан юм?

Хариулт:-40, 41 оны хавьцаа явсан болов уу, намайг сургуульд сууж байхад лам баригдаж бариад явж байсан. Тэр улсуудаас лав л миний мэдэх хоёр хүн ирсэн.

Асуулт:- Эргэж ирсэн?

Хариулт:- Манай энэ самганы нагац болдог хүн Лувсангомбо гэдэг хүн ирж байсан.

Асуулт:-Арын хүрээний лам байсан юмуу?

Хариулт:-Тийм. **Лувсанбандгай** гэж хүн лав л 10 жил яваад ирж байсан, сүүлд нь бүр 50 хэдэн онд ирж байсан.

Асуулт:-Арын хүрээний барилга байшинг бүрэн бүтэн байхад нь харж байсан уу, ямархуу хэв маягтай?

Хариулт:-Барилгын хувьд хамгийн том барилга нь Цогчэн дуган гэж том дуган байсан л даа, тэрний хана нь намайг цэрэгт явах хүртэл байж л байсан.

Асуулт:-Юугаар барьсан байсан юм бол тоосго уу, мод уу?

Хариулт:-Дандаа түүхий туйпуу.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Монголчууд барьсан уу?

Хариулт:-Том барилга бол 3, 4 барилга байсан юм шиг байна лаа, шавыг нь хараад байхад. Бусад нь жижиг лам нарын орон сууц дандаа тийм шавар амбаарууд байсан юм шиг байдаг юм.

Асуулт:-Арын хүрээн дээр улааны **ёсны жод, лүйжин** тавьдаг байсан лам байсан уу?

Хариулт:-Тэр үед тийм юм байгаагүй юм шиг байгаа юм. Майдар эргэж байна гэж намайг багад бүрээ бишгүүр үлээсэн тийм юм болж байсан юм. Лав л **Майдар** эргэж байсан юм. Тэрнийг би муухан мэдээд байгаа юм, бүүр түүр.

Асуулт:-Зуны сард л эргэдэг байсан байлгүй **Майдар** ?

Хариулт:-Бурханы хувьд янз бүрийн бурхан зурмал, суумал, гуулин **бурханууд** зөндөө л байсан даа.

Асуулт:-Ганжуур, **Данжуур гээд** том судрууд байсан уу?

Хариулт:-Ганжуур, **Данжуур** нь чухам хаачсан юм мэдэхгүй, байхын хувьд байсан гэж байгаа юм. **Тэгээд тэрнийг** шатаачихсан юмуу, ачаад явчихсан юмуу. Тэрнийг ачсан гэж байгаа юм, бас хэсэг юмыг нь, хэрэгтэй юмыг нь. **Тэр үед** чинь **Зис** байсан юм байгаа биз дээ. Тийм машинаар хэрэгтэйг нь тусгай үлсүүд ирээд ачаад тэгээд машинаа тавьчихсан байж л дээ. Тэр машин бас тийм амар газар бишээ, хошуу тойроод ингээд явдаг. Тэр машин тэр дотор ороод ирчихсэн явж байсан гэж байгаа юм, **араагий** нь мултлаад хаячихсан байсан юмуу, чухам ямар учиртай байсан юм. Тэгж хуучуул ярьдаг л байсан.

Асуулт:-Арын хүрээний ойролцоо тахилгатай уул овоо байна уу?

Хариулт:-Энэ цаад улаан давааны овоотой доо.

Асуулт:-Тэрнийг Арын хүрээний лам нар тахидаг байсан уу?

Хариулт:-Тийм. Энэ урагшаа сүмийн урагшаа **Батбуянтын** овоо гэж байгаа, тэр овоог тахиж байсан гэж байгаа юм.

Асуулт:-Цагаан идээгээр тахиж уу? шүүсээр тахиж уу?

Хариулт:-Шүүс тавиад, цагаан идээтэй тэгж тахиж байсан юм байна лээ. Сүүлийн үед намайг том болсон хойно шүүс тахиж байсан.

Асуулт:-Наадам хийх үү? Овоогоо **тахичихаад**

Хариулт:-Тухайн үедээ барилддаг, морь уралддаг тийм байсан.

Асуулт:-Арын хүрээн дээр ном судраа хэвлэдэг бар байсан юм болов уу?

Хариулт:-Тэрнийг сайн мэдэхгүй юм.

Асуулт:-Тэр хүрээн дээр алдартай том лам нар байсан уу? хутагт хувилгаад, гэгээнтэн ч юмуу?

Хариулт:-**Байчуулангаас** өөр тийм цол мяндагтай лам байгаагүй, гэлэн санваартан үлсүүд байсан байх л даа.

Асуулт:-Энэтхэг, Төвдийн хийдүүдтэй холбоотой байсан юм болов уу, Арын хүрээ? Лам нараа сургадаг, нааш цааш нь явуулдаг.

Хариулт:-Хонгорын хүрээ бол **Нарованчигийн** хүрээ гэж бий шүү дээ. Эд нартай их холбоотой байсан юм байна лээ. Тонхилын Зүйлийн хүрээ, Бигэр номун хааны хүрээ хоорондоо шашныхаа талаар холбоотой хоорондоо

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

одоогоор төлөөлөгч сольж байсан юм байна лээ. Шашныхаа талыг зөв явуулж байна уу гэдэг ч юмуу тэр талаараа, тийм байсан харагддаг юм.

Асуулт:-Арын хүрээний овоо тахилгын судар байдаг болов уу, айлуудад?

Хариулт:-Тэрнийг сайн мэдэхгүй юм.

Асуулт:-Арын хүрээний жас мал хүйг нь мэдэх үү? Хүрээний жасын мал.

Хариулт:-Жасын мал гэсэн юм бий л дээ.

Асуулт:-Хэд орчим малтай байсан юм бол?

Хариулт:-Арын хүрээний сан жас адуу 184, тэмээ 34, үхэр 366, хонь, ямаа нийлээд 2800, энэ хошуу сүргийг эзэмшигчдийн байдлаар.

Асуулт:-Хэдэн оны үе **байхав?**

Хариулт:-1918-аас өрх 640, эр хүн 549, үүнээс тайж 32, хамжлага ард 54, лам 83, албат ард 287, бусад чөлөөт сул ард 93, эмс охид 515, бүгд хүн 1064 хүн байсан байна гэж.

Асуулт:-1918 оны үед ийм байна тийм ээ?

Хариулт:-Тийм. Хошуу гэж байхад л ийм байсан юм байна лээ.

Асуулт:-Энгийн хүмүүс нь энэ хийдийн малыг малладаг байсан уу?

Хариулт:-Жасын мал малладаг улсууд байсан л даа.

Асуулт:-Хар хүмүүс байсан уу, лам нар байсан юмуу?

Хариулт:-Хар улсууд. Жасын үхэр хариулдаг гэж манай хөгшчүүл ярьдаг л байсан даг.

Асуулт:-Арын хүрээ хошуу ноёндoo ч юмуу, албан татвар төлдөг байсан уу?

Хариулт:-Жинхэнэ Арын хүрээ байж байх үед Цэвэгжав гэж ноён байсан юм. Балай ноён гэдэг юм даа. Тэр бол ард түмнээсээ алба татвар авна гэж байдаггүй, өөрөө их номтой хүн байсан байгаа юм. Лам нартай их ном хаялцдаг, тийм хүн байсан гэж ярьдаг юм билээ.

Асуулт:-Арын хүрээнд **чойрын** ном үздэг байсан уу? Гүн ухааны ном.

Хариулт:-Чойрын ном байсан гэсэн. Тэнд чинь бас **маарамбанууд** байсан байгаа юм, эмнэлгийн талын. Манба дацан гэж байсан. Чойрын ном гэдэг нь одоогоор бол улс төр, шинжлэх ухааны л юм даа.

Асуулт:-Зурхай үздэг байсан уу?

Хариулт:-Үздэг байсан.

Асуулт:-Хэдэн оны үед барилга байсан нь байхгүй болов?

Хариулт:-Тарах нь уу?

Асуулт:-Тийм.

Хариулт:-1939 оны эхэнд юм болов уу. Намар тарааж, өвөл тэр үеийн Аюулаас хамгаалахын улсууд ирж юмыг нь хурааж байсан юм шиг байна лээ. Лам нар нь тараад явчихсан.

Асуулт:-Тэгээд бурхан шүтээн янз бүрийн юмыг нь хураагаад.

Хариулт:-Тэгээд тэнд чинь янз бүрийн юм зөндөө л байгаа л даа, тараад явчихсан хойгуур бол. **Эзэнгүйрчихээр.**

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Хонгорын хүрээг ярьж өгнө үү.

Хариулт:-Хонгорын хүрээний түүхийг нэг их сайн дуулаагүй.

Асуулт:-Ер нь тэнд сууж байсан лам нараас мэдэх үү, таних уу?

Хариулт:-Тэндээс лав л дээгүүр голд чинь Цэвээн унзад гэж хүн байсан. Тэр 10 жил явж байгаад ирсэн. Бага байхад тэрнээс яаж явсан **тэр талаар** ямар асууж сурна гэх биш.

Асуулт:-Өөр танд Хонгорын хүрээний талаар мэдэх юм байна уу?

Хариулт:-Өөр Хонгорын хүрээний талаар мэдэх хүн тун ховор болчихжээ. Сүмийн тэнд **Загарваа** гэж хүн бий. Тэр бага байсан гэхдээ тэр нэлээн дуулж мэдсэн байх. Тэр тэнд нутагладаг байсан хүн л дээ, аав ээж нь.

Асуулт:-Хонгорын хүрээний ойролцоо юу?

Хариулт:-Тэр хавиар л нутаглаж байсан. Тэр нэг бүүр түүр юм мэдэж магадгүй. Надаас 4, 5 дүү хүн л дээ. Хонгорын хүрээний талаар би нэг их дуулаад байсан юм байхгүй.

Асуулт:-Сүүлд та лам нарыг нь тарчихсан хойно барилга **байшингий нь** харж байсан уу? Бүрэн бүтэн байхад нь.

Хариулт:-Хараагүй.